



МОНГОЛ УЛСЫН  
ДЭЭД ШҮҮХ

# 2022 ОНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот



## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА


1. ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....	3
1.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....	4
1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....	5
1.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....	6
2. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ.....	7
2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....	7
2.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....	10
2.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....	12
3. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА.....	14
4. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР.....	15
4.1. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА.....	16
4.2. ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА.....	22
4.3. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДЛАЛ.....	23
4.4. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛ.....	26
4.5. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	28
4.6. САНХҮҮ, НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ.....	29
4.7. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТ.....	30

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2022 ОНЫ ТАЙЛАН


### 1.ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Монгол Улсын дээд шүүх хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд хяналтын журмаар гаргасан гомдлуудыг хүлээн авч хянан шийдвэрлэх ажиллагаа явуулав.

#### Монгол Улсын дээд шүүхэд хүлээн авсан нийт 4087 хэрэг



#### Монгол Улсын дээд шүүхэд 2022 онд хүлээж авсан хэргийг 2021 онтой харьцуулсан үзүүлэлт




Монгол Улсын дээд шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийг Танхим тус бүрээр авч үзвэл:

### 1.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **40** хэрэг, нэмж хяналтын шатны журмаар **809**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **19**, нийт **868** хэрэг хүлээн авснаас **858** хэргийг хэлэлцэн дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шийдвэрлэсэн **670**, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн **188**, үлдэгдэл **10** хэрэг байна.

График 1



Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **188** хэргийн **22.4** хувь буюу **42** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **38.3** хувь буюу **72** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **39.3** хувь буюу **74** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.

Өөрчлөлт оруулсан **72** хэргийн **70.8** хувь буюу **51** хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, **1.4** хувь буюу **1** хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр өөрчлөлт тус тус оруулж, **27.8** хувь буюу **20** хэргийн зүйлчлэл өөрчлөлгүйгээр ялыг хөнгөрүүлсэн байна.

Хүчингүй болгосон **74** хэргийн **14.9** хувь буюу **11** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан, давж заалдах шатны шүүхэд буцааж, **47.2** хувь буюу **35** хэргийн шийтгэх, цагаатгах тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож, **14.9** хувь буюу **11** хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, **21.7** хувь буюу **16** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийтгэх, цагаатгах тогтоолыг хэвээр үлдээж, **1.3** хувь буюу **1** хэргийн шийтгэх, цагаатгах тогтоолын зарим заалтыг хүчингүй болгосон байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **188** хэргийн **32** хувь буюу **60** хэргийг шүүгдэгчийн, **7.4** хувь буюу **14** хэргийг хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн, **27.6** хувь буюу **52** хэргийг өмгөөлөгчийн, **1.6** хувь буюу **3** хэргийг иргэний хариуцагчийн, **18.6** хувь буюу **35** хэргийг улсын яллагчийн эсэргүүцлээр, **12.8** хувь буюу **24** хэргийг прокурорын дүгнэлтээр хэлэлцжээ.

Хяналтын шатын эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **188** хэргийг зүйлчлэлээр авч үзвэл:


Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлээр **22**, 11.1 дүгээр зүйлээр **8**, 11.4 дүгээр зүйлээр **3**, 11.6 дугаар зүйлээр **8**, 12.1 дүгээр зүйлээр **45**, 13.1 дүгээр зүйлээр **2**, 17.1 дүгээр зүйлээр **7**, 17.2 дугаар зүйлээр **2**, 17.3 дугаар зүйлээр **14**, 17.4 дүгээр зүйлээр **3**, 17.12 дугаар зүйлээр **3**, 20.7 дугаар зүйлээр **2**, 22.4 дүгээр зүйлээр **3**, 22.5 дугаар зүйлээр **2**, 27.10 дугаар зүйлээр **22**, бусад зүйл, хэсгээр **42** хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Тайлант онд Эрүүгийн хэргийн танхим **145** албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллажээ.

## 1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **116** хэрэг, нэмж хяналтын шатны журмаар **2488**, харьяалал тогтоолгохоор **21**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **58**, Ерөнхий шүүгч дүгнэлт бичсэн **1**, нийт **2684** хэрэг хүлээн авснаас **2668** хэргийг хэлэлцэн дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шийдвэрлэсэн **1237**, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн **1291**, гомдол гаргаагүйд тооцсон **58**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцсэн **60**, шүүхийн харьяаллыг тогтоосон **21**, Ерөнхий шүүгч дүгнэлт бичиж иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хянан хэлэлцсэн **1**, үлдэгдэл **16** хэрэг байна.

График 2



Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн иргэний **1291** хэргийн **59.6** хувь буюу **770** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **9.8** хувь буюу **125** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **17** хувь буюу **219** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **10.9** хувь буюу **141** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **2.7** хувь буюу **36** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Өөрчлөлт оруулсан **219** хэргийн **74.9** хувь буюу **164** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **25.1** хувь буюу **55** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан **125** хэргийн **51.2** хувь буюу **64** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **32.8** хувь буюу **41** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, **16** хувь буюу **20** хэргийг оролцогчийн эрхийг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **36** хэргийн **55.6** хувь буюу **20** нь зохигчийн эвлэрлийг баталсан, **44.4** хувь буюу **16** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй **60** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд **58** хүсэлтийг хангаагүй, **2** хүсэлтийг хангаж, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэхээр буцаасан байна.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **30.1** хувь буюу **388** нэхэмжлэгчийн, **63.1** хувь буюу **815** хариуцагчийн, **4.4** хувь буюу **57** зохигчийн, **2.4** хувь буюу **31** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1291** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:


Иргэний хуулиар **1136**, Хөдөлмөрийн тухай хуулиар **43**, Гэр бүлийн тухай хуулиар **6**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **5**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **13**, бусад хуулиар **88** хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Тайлант онд Иргэний хэргийн танхим **94** албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллажээ.

### 1.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Захиргааны хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **15** хэрэг, нэмж хяналтын шатны журмаар **510**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **10**, нийт **535** хэрэг хүлээн авснаас **532** хэргийг хэлэлцэн дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шийдвэрлэсэн **438**, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн **84**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцсэн **10**, үлдэгдэл **3** хэрэг байна.

График 3



Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **84** хэргийн **34.5** хувь буюу **29** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **25** хувь буюу **21** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **40.5** хувь буюу **34** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **34** хэргийн **64.7** хувь буюу **22** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулж, **20.6** хувь буюу **7** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцааж, **14.8** хувь буюу **5** хэргийн нэхэмжлэлийг болон хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **21** хэргийн **100** хувь буюу **21** хэргийг шүүх хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулсан байна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **84** хэргийн **51.2** хувь буюу **43** итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **17.9** хувь буюу **15** нэхэмжлэгчийн, **11.9** хувь буюу **10** өмгөөлөгчийн, **8.3** хувь буюу **7** хариуцагчийн, **10.7** хувь буюу **9** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **84** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл: газрын маргаан **9**, ашигт малтмалын маргаан **9**, төрийн албаны маргаан **9**, төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **2**, татварын маргаан **11**, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой маргаан **2**, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой маргаан **5**, гааль, гаалийн улсын байцаагчийн дүгнэлттэй холбоотой маргаан **2**, мэргэжлийн хариуцлагын хорооны **11**, давж заалдах журмаар гаргасан гомдолтой **7**, бусад хуулиар **17** хэргийг тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Тайлант онд Захиргааны хэргийн танхим **59** албан бичиг, өргөдөл гомдол, Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой **26** өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.

## 2.ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ:

### 2.1.Эрүүгийн хэргийн танхим

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тайлбарлах тухай	Шүүгч Б.Батцэрэн
2.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
3.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлын талаарх зохицуулалтыг тайлбарлах талаар танилцуулга, холбогдох материалыг бэлтгэж Нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсан	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
4.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан шүүгчийг татгалзан гаргах зохицуулалтыг тайлбарлах талаар танилцуулга, холбогдох материалыг бэлтгэж Нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсан	Шүүгч Б.Батцэрэн

Бичсэн ном, гарын авлага:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик” сэдэвт гарын авлагын хариуцсан сэдвүүдийг бичсэн	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Б.Амарбаясгалан, Шүүгч С.Батдэлгэр, Шүүгч Б.Батцэрэн, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн

2.	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт гарын авлага бичихэд оролцсон	Шүүгч Б.Батцэрэн
----	--	------------------

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Шүүхийг сурвалжлах нь-2021” сэтгүүлчдэд зориулсан сургалтад “Авлига, албан тушаалын гэмт хэрэг” сэдэвт хичээл	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
2.	“Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг” сэдвээр 10 цагийн хичээл	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
3.	Эрүүгийн хэргийн шүүгчдэд “Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой материаллаг болон процессын хэм хэмжээнүүдийн шинж, хоорондын ялгаа” сэдэвт 3 цагийн хичээл	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
4.	“Мөнгө угаах гэмт хэрэг” сэдвээр Эрүүгийн хэргийн шүүгчдэд 5 удаагийн хичээл	Шүүгч Б.Амарбаясгалан
5.	“Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ - 2” сэдэвт хичээл	Шүүгч Б.Амарбаясгалан
6.	Шүүгчдэд “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа” сэдэвт хичээл	Шүүгч Б.Батцэрэн
7.	Шүүгчдэд “Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлд заасан төсөв хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг” сэдэвт хичээл	Шүүгч Б.Батцэрэн
8.	Шүүгчдэд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тухай” хичээл	Шүүгч Б.Батцэрэн
9.	Эрүүгийн хэргийн шүүгчдэд “Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик” сэдэвт хичээл	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүдтэй мөрдөн шалгах ажиллагааны явцад мэдээлэл цуглуулах, үр дүнтэй ярилцлага хийх “Мендезийн зарчим”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой хэлэлцүүлэг	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Б.Амарбаясгалан, Шүүгч С.Батдэлгэр, Шүүгч Б.Батцэрэн, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
2.	Азийн хөгжлийн банк, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Эмэгтэйчүүд болон охидын хүчирхийллийн эсрэг тэмцэх албан ёсны хуулийн тогтолцоог бэхжүүлэх” сэдэвт олон улсын конференци	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
3.	Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Б.Батцэрэн, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
4.	“Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал” эрдэм шинжилгээний хуралд оролцож, эрүүгийн эрх зүйн салбарын илтгэлийг хааж дүгнэсэн	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
5.	“Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” (2021-2024) гурван жилийн хугацаат шинэ төслийн нээлт	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
6.	Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан болон үр дагаврын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч Рем Алсалемтай хийсэн цахим уулзалт	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
7.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан хуралдаан	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
8.	МУИС-ийн Хууль зүйн сургуулиас санаачлан Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан “Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, тэдгээрийн эрх	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр



	зүйн хийдэл, даван туулах арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал	
9.	Шүүгчийн сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны хурал	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
10.	Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Аксель Никейзийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авсан уулзалт	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
11.	Франц Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сэбастиен Сүрүнийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авсан уулзалт	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
12.	Хүний эрхийн комиссоос зохион байгуулсан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхдийн эрх” сэдэвт хэлэлцүүлэг	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
13.	НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны болон Сингапур, Буркина Фасо Улсын шинжээчид Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 болон 5 дугаар бүлгийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний уулзалт	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
14.	Урд бүсийн аймгуудын эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчидтэй хийсэн уулзалт	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Б.Батцэрэн

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Хууль хэрэглээний нэгдмэл тайлбар толь” бүтээх ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүгч Б.Амарбаясгалан, Шүүгч С.Батдэлгэр, Шүүгч Б.Батцэрэн, Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
2.	Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооноос шүүгчдийн дунд зохион байгуулсан “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааны ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
3.	Эрүүгийн эрх зүйн чиглэлээр шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
4.	“Шүүгч олон нийттэй харилцах” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
5.	Эрүүгийн эрх зүйн чиглэлээр 2023 онд зохион байгуулах шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
6.	Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Б.Амарбаясгалан
7.	Хуульчийн сонгон шалгаруулалтад оролцогчдын эрүүгийн эрх зүйн бодлого дүгнэх комиссын гишүүн	Шүүгч Б.Амарбаясгалан
8.	Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Б.Батцэрэн
9.	“Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”-ийн гишүүнээр ажиллаж “Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн өсвөр насны ял шийтгүүлэгчдийн талаарх судалгаа”-г гаргаж хүргүүлсэн	Шүүгч С.Батдэлгэр
10.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтын хэрэгжилтийг судалж, санал гаргах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Б.Цогт
11.	Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
12.	Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх арга зүйг тодорхойлох мэдээллийн дэд бүтцийг оновчтой болгох, холбогдох журам, баримт бичгийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
13.	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны цаг хугацаа, шат дараалал, судлах,	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн

	туслах чиг үүрэг бүхий үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор уг харилцааг зохицуулах дотоод журмыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн	
--	---	--

Контент бүтээх ажлын оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтын “Нотлох баримт, түүнийг үнэлэх” сэдэвт хичээлийн 2 цагийн контентын бичлэгт орсон	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
2.	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сургалтын контент хийхэд оролцсон	Шүүгч Б.Батцэрэн
3.	Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтын “Мэтгэлцэх ур чадвар” сэдэвт хичээлийн 2 цагийн контентын бичлэгт орсон	Шүүгч Б.Батцэрэн

## 2.2.Иргэний хэргийн танхим

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийг тайлбарлах тухай	Иргэний хэргийн танхимын шүүгчид

Бичсэн ном, гарын авлага:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн сургалтын гарын авлагын эмхэтгэл	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
2.	Шүүгчийн сургалтын хөтөлбөр	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
3.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захиалгаар “Захиргааны гэрээ, Иргэний хуулийн нөхөн зохицуулалт” сэдэвт сургалтын хөтөлбөрүүд	Шүүгч Г.Банзрагч
4.	“Төрийн ба хувийн өмчийн газар ашиглалтын өнөөгийн байдал: Газрын тухай хуульд хийсэн эдийн баялгийн эрх зүйн шинжилгээ”, “Төрийн байгууллагын эрх зүйн байдал”, “Газар ба үл хөдлөх эд хөрөнгө: Газрын хэвлийн баялаг ба хувьцаа” зэрэг сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ажил	Шүүгч Н.Баярмаа
5.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захиалгаар “Төлбөрийн чадваргүйдлийн эрх зүй” сэдвээр сургалтын хөтөлбөр, 8 видео хичээл	Шүүгч Н.Баярмаа
6.	Гэр бүлийн эрх зүйн сургалтын гарын авлага	Шүүгч П.Золзаяа
7.	2022 оны Иргэний сургалтын бодлого, аргачлал	Шүүгч П.Золзаяа, Шүүгч Х.Эрдэнэсүвд

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдэд зориулсан сургалтад “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл” сэдэвт сургалт	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
2.	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдэд зориулсан сургалтад “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 97.1, 97.2, 170.1, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрхэн хэрэглэх тухай” сэдэвт сургалт	Шүүгч Г.Банзрагч
3.	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдэд зориулсан сургалтад “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх	Шүүгч П.Золзаяа

	тухай хуулийн 74, 106 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалт	
4.	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдэд зориулсан сургалтад “Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх онцлог, анхаарах асуудал” сэдэвт сургалт	Шүүгч Д.Цолмон
5.	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдэд зориулсан сургалтад “Улсын тэмдэгтийн хураамж хуваарилах талаар” сэдэвт сургалт	Шүүгч Х.Эрдэнэсүвд
6.	Баруун бүсийн аймгуудын шүүхийн сургалтад иргэний хэргийн шүүгч нарт зориулж “Шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй, Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал, Улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилах” сэдэвт сургалтууд	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Шүүгч Г.Банзрагч, Шүүгч Д.Цолмон
7.	Захиргааны хэргийн шүүгчдэд зориулсан сургалтад “Захиргааны гэрээ ба Иргэний хуулийн нөхөн зохицуулалт” сэдвээр 4 цагийн хичээл	Шүүгч Г.Банзрагч
8.	Шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан сургалт	Шүүгч Н.Баярмаа

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, Ханнс-Зайделийн сан, МУИС-ын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал” сэдэвт дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцож, эрдэм шинжилгээний хурлыг дүгнэж үг хэлсэн	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
2.	МУИС байгуулагдсаны 80 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хуралд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хөгжил: “Иргэний хэрэг”-ийн тухай зарим асуудал сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн	Шүүгч Н.Баярмаа

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Хууль хэрэглээний нэгдмэл тайлбар толь” бүтээх ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Шүүгч Г.Банзрагч, Шүүгч Н.Баярмаа, Шүүгч П.Золзаяа, Шүүгч Д.Цолмон
2.	Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх арга зүйг тодорхойлох, мэдээллийн дэд бүтцийг оновчтой болгох, холбогдох журам, баримт бичгийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Г.Банзрагч, Шүүгч П.Золзаяа
3.	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны цаг хугацаа, шат дараалал, судлах, туслах чиг үүрэг бүхий үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор уг харилцааг зохицуулах дотоод журмыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Г.Банзрагч, Шүүгч П.Золзаяа
4.	Иргэний эрх зүйн чиглэлээр шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
5.	Иргэний эрх зүйн чиглэлээр шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Н.Баярмаа, Шүүгч П.Золзаяа, Шүүгч Х.Эрдэнэсүвд
6.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Шүүгч Н.Баярмаа, Шүүгч П.Золзаяа
7.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс санаачлан Монголын Хуульчдын холбооны сайн дурын хороо,	Шүүгч Г.Банзрагч

	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн болон “Легалдата судалгааны цахим сантай хамтран зохион байгуулсан “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг дүгнэх комиссын гишүүн	
8.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн	Шүүгч П.Золзаяа
9.	Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэг, Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний дэгд өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч П.Золзаяа
10.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтын хэрэгжилтийг судалж, Шүүгчдийн зөвлөгөөнд санал гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Х.Эрдэнэсүвд
11.	“Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Х.Эрдэнэсүвд

### 2.3.Захиргааны хэргийн танхим

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын албан ёсны тайлбар	Танхимын тэргүүн Ч.Тунгалаг
2.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	Монгол Улсын дээд шүүхийн танхимын нийт шүүгчийн хуралдааны журам	Шүүгч Ц.Цогт
4.	Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд бэлтгэх журам	Шүүгч Ц.Цогт

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч” сургалтад “Шүүгчийн хараат бус аюулгүй байдал, нөлөөллийн мэдүүлэг” сэдэвт хичээл	Шүүгч Ц.Цогт
2.	Баруун бүсийн аймгуудын шүүгчдэд зориулсан сургалт	Шүүгч Ц.Цогт
3.	Сэтгүүлч нарт зориулсан сургалт	Шүүгч М.Батсуурь
4.	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүхийн захиргааны ажилтныг сургагч багш болгон мэргэшүүлэх” сургалтад “Шүүхийн захиргааны ажилтны сургалтын сургагч багшийн оролцоо, анхаарах асуудал” сэдэвт хичээл	Шүүгч Ц.Цогт

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Налайх, Багахангай дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгуудын шүүхийн шүүгч нарт зориулсан илтгэл	Шүүгч М.Батсуурь
2.	Монгол Улсын дээд шүүхээс санаачилж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх нь” сэдэвт уулзалт	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүгч П.Соёл-Эрдэнэ
3.	ХБНГУ-ын нийслэл Берлин хотод зохион байгуулсан “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чадавхыг сайжруулах” төслийн хэрэгжилтийг хэлэлцэх хурал	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академийн дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулсан “Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг,	Шүүгч П.Соёл-Эрдэнэ

	маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурал	
4.	Канадын Холбооны Улсын Оттава хотод зохион байгуулагдсан Олон улсын шүүхийн 10 дугаар бага хурал	Шүүгч Ц.Цогт
5.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай хийсэн уулзалт	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
6.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүх байгуулах ажлын хэсгийн зөвшилцөх уулзалт	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
7.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нартай хийсэн уулзалт	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
8.	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” эрдэм шинжилгээний бага хурал	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
9.	Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн шүүхүүдэд зохион байгуулсан ярилцлага, уулзалт	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
10.	“Шүүхэд хандах эрх, хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, эрх хэмжээ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
11.	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Лакноу хотноо зохион байгуулагдсан 23 дахь удаагийн Дэлхийн Ерөнхий шүүгч нарын чуулга уулзалт	Шүүгч М.Батсуурь
12.	Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан хамтран зохион байгуулсан “Шүүхэд хандах эрх: Хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, эрх хэмжээ” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд “Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо дахь Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагааны чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь” сэдвээр илтгэл	Шүүгч Ц.Цогт
13.	МУИС-ийн Хууль зүйн сургууль зохион байгуулсан “Монгол Улсын процессын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, тулгамдсан асуудал” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захиргааны эрх зүйн секторын судлаач С.Цэрэндолгорын хамт “Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь” сэдвээр илтгэл	Шүүгч Ц.Цогт (хамтарсан)

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Хууль хэрэглээний нэгдмэл тайлбар толь” бүтээх ажлын хэсгийн ахлагч	Шүүгч Ц.Цогт
2.	“Хууль хэрэглээний нэгдмэл тайлбар толь” бүтээх ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	“Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх журмын төсөл” боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Шүүгч М.Батсуурь
4.	“Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, арга зүйг тодорхойлох, мэдээллийн дэд бүтцийг оновчтой болгох, холбогдох журам, баримт бичгийн төсөл” боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
5.	“Монгол Улсын дээд шүүхийн стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
6.	Шүүх эрх мэдэл хөгжлийн бичиг баримтыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
7.	Шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
8.	Шүүхийн шийдвэрийн хураангуй боловсруулах ажлын хэсгийн ахлагч	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
9.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтын хэрэгжилтийг судалж, санал гаргах үүрэг бүхий хэсгийн гишүүн	Шүүгч Ц.Цогт

10.	Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Ц.Цогт
11.	“Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх журам” боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Ц.Цогт
12.	Шүүхийн байгууллагад мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Х.Батсүрэн

### 3.ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА

Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлыг тусгайлан зохицуулсан бөгөөд хуралдааныг тасралтгүй, хэвийн явуулах ажлыг зохион байгуулалтаар ханган хэрэгжүүлэх чиг үүргийг Тамгын газрын дэмжлэгтэйгээр Ерөнхий шүүгчийн Ажлын алба хариуцан ажиллаж байна.

Тайлант онд нийт шүүгчийн хуралдаан 13 удаа товлогдож, 51 асуудлыг, Шүүгчдийн зөвлөгөөн 7 удаа товлогдож 12 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсний дотор хууль тайлбарласан 5 тогтоол (Хүснэгт 1), шүүхийн дотоод ажлын зохион байгуулалттай холбоотой 2 журам (Хүснэгт 2) хэлэлцэн баталжээ.

**Хуулийг зөв хэрэглэх талаар Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас гаргасан албан ёсны тайлбарууд**

Хүснэгт 1

№	Тогтоолын нэр	Тогтоолын он, сар, өдөр	Дугаар
1.	“Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тайлбарлах тухай	2022.02.09	07
2.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийг тайлбарлах тухай	2022.02.28	09
3.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар	2022.03.09	11
4.	Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын албан ёсны тайлбар	2022.03.31	13
5.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	2022.12.14	36

### Монгол Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөр баталсан журмын жагсаалт

Хүснэгт 2

№	Журмын нэр	Журмын он, сар, өдөр	Дугаар
1.	Монгол Улсын дээд шүүхийн танхимын нийт шүүгчийн хуралдааны журам батлах тухай	2022.04.18	02
2.	Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд бэлтгэх журам батлах тухай	2022.10.26	08

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хуульд заасны дагуу хариу өгч шийдвэрлэн ажиллажээ.

Хуульд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон шүүхийн удирдлага зохион байгуулалттай холбогдуулан гаргасан Ерөнхий шүүгчийн захирамжийн албан ёсны хүчин төгөлдөр байдлыг хангуулан ажилласан байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч төсвийн ерөнхийлөн захирагчийн ажлын хүрээнд байгууллагын бодлого төлөвлөлт, стратегийн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг ханган биелүүлэхэд шүүхийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн зохион байгуулах чиг үүргийн хүрээнд хуульд заасан хугацаанд тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж “Зөрчилгүй” санал дүгнэлт авч, 2023 оны төсвийн төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Аксель Никэйз, Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Себастиан Сүрүн, Ханнс-Зайделийн сангийн Зүүн хойд болон Төв Азийн хэлтсийн дарга Дебора Тидекс-Жоу, Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Феликс Гленк нарыг хүлээн авч уулзан, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон, мөн Ази, Номхон далайн бүсийн орнуудын Ерөнхий шүүгчдийн 18 дугаар хуралд цахимаар оролцсон байна.


#### 4.МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Тамгын газар нь Улсын дээд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүргийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан ажиллав.



#### 4.1.ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн Хөдөлмөрийн дотоод журам, төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, төрийн үйлчилгээний ажилтны ажлын байрны тодорхойлолтууд, Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Шинэ ажилтны дасан зохицох дэд хөтөлбөр зэргийг батлан хэрэгжүүлсэн байна.



2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 3 шүүгч томилогдон, 1 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарсан байна.



Хяналтын шатны шүүх бүрэлдэхүүний тоон мэдээллийг нэгтгэн харвал:



**УЛСАД АЖИЛЛАСАН ХУГАЦАА:**


10-20 жил-3 шүүгч  
21-30 жил-11 шүүгч  
31 ба түүнээс жил-7 шүүгч

**ШҮҮГЧЭЭР АЖИЛЛАСАН ХУГАЦАА:**

10 хүртэл жил-3 шүүгч  
10-20 жил-13 шүүгч  
21-30 жил-4 шүүгч  
31 ба түүнээс жил-1 шүүгч


Хяналтын шатны шүүхийн хэвийн тасралтгүй байдлыг ханган ажиллахад хүний нөөцийн чадавх, тэдгээрийн тогтвортой байдал чухал үүрэгтэй. Тамгын газрын хүний нөөцийн тоон мэдээллийг нэгтгэн харвал:

**БОЛОВСРОЛ**




■ БАКАЛАВР      ■ МАГИСТР  
■ ТУСГАЙ ДУНД    ■ ДОКТОРАНТ

**МЭРГЭЖИЛ**




## АЛБАН ХААГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА



## Төрийн захиргаа

75



## Төрийн захиргаа 115 Төрийн үйлчилгээ



- 21-25 нас
- 26-30 нас
- 31-35 нас
- 36-40 нас
- 41-45 нас
- 46-50 нас
- 51-55 нас
- 56-60 нас
- 61-аас дээш




Хүний нөөцийг сургаж, хөгжүүлэх асуудлыг нэгтгэн зохион байгуулах, үр дүнг тооцох зорилгоор Сургалт, хөгжлийн төвийг байгуулан ажиллуулсан.

Тайлант хугацаанд зохион байгуулсан зарим сургалтуудыг дурдвал, Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6 албан хаагчийг, “Хуульчийн үргэлжилсэн сургалт”-д хуульчийн гэрчилгээтэй 33 албан хаагчдыг, Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтад 10 албан хаагчийг, Төрийн албаны зөвлөл, Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн нэгжтэй хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёлоо бүтээх нь” сургалтад Тамгын газрын нийт албан хаагчдыг хамруулсан байна.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд:



2022 онд хүлээн авсан хэрэг, албан бичиг, өргөдөл гомдлыг 2021 онтой харьцуулсан үзүүлэлт:



Архивын хөмрөгийн сан бүрдүүлэлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, байнга хадгалах 184, түр хадгалах 120, 70 жил хадгалах 6, нийт 310 хадгаламжийн нэгж хүлээж авч, 62 хүнд 223 хуудас баримтыг хуулбарлан лавлагаа өгч, 12 хадгаламжийн нэгжийн гадна хавтсыг сольж, дотоод товъёог шинээр үйлдсэн байна.

## АРХИВЫН БАРИМТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛСЭН.


1996-2006 оны Дээд шүүхийн тогтоол, тэмдэглэл, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Хяналтын шатны Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж, Нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, тэмдэглэл, Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, тэмдэглэл, Тамгын газрын даргын тушаал зэрэг 334 хадгаламжийн нэгж бүхий 42924 хуудас архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлээд байна.

**334** ХАДГАЛАМЖИЙН  
НЭГЖ БҮХИЙ

**42924** ХУУДАС АРХИВЫН  
БАРИМТЫГ ЦАХИМ  
ХЭЛБЭРТ



Монгол Улсын дээд шүүхийн номын санд электрон хайлт бүхий Коха нэгдсэн системийг нэвтрүүлж, Монгол, Англи, Орос болон бусад хэлээр хэвлэгдсэн 6022 номыг бүртгэлжүүлэн хэрэглээнд нэвтрүүлжээ.




Шүүгчийн хараат бус байдлыг хангах:

Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүгчийн амь нас, эрүүл мэндэд нь хохирол учирсан тохиолдолд даатгалын бусад төрлөөс үл хамааран олгогдох заавал даатгагдах албан журмын даатгалын төрлийг хуульчилсан. Энэ ажлын хүрээнд зохих хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгарсан даатгалын компанитай Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулж, 4 шүүгчид даатгалын нөхөн төлбөрийг гаргуулжээ.



**Цагаатгалын ажил:**

Тайлант онд Улсын Ерөнхий Прокурорын газраас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн нийт 24 цагаатгалын хэрэг хүлээн авч, үүнээс 25 хэлмэгдэгчид холбогдох 24 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн.



Хэлмэгдэгчдийн төрөл садангаас цагаатгуулах хүсэлт 1, нөхөн олговор олгуулах хүсэлт 2 тус тус ирүүлснийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн. Энэ хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан нийт 22 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, үүнээс 10 цагаатгалын үнэмлэх (шинээр-9 үнэмлэх, нөхөн-1 үнэмлэх) олгож, 6 өргөдөл, хүсэлтэд зохих журмын дагуу хариу өгсөн.

Нөхөх олговор олгосон бүртгэлд нийт 132 шүүхийн шийдвэрүүдийн мэдээллийг бүрэн оруулжээ.

Техник, программ хангамж:

Монгол Улсын дээд шүүхийн мэдээллийн технологи, аюулгүй байдлын цогц системийг шинэчлэх ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, сүлжээний аюулгүй байдал болон эрсдэлийн үнэлгээг хийн, сүлжээний ерөнхий топологи зургийг шинэчлэн зурсан.


Хяналтын шатны шүүх хуралдаанд 1643 удаа техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, 150 ширхэг оффис болон үйлдлийн системийн лиценз худалдан авч, шүүгчид болон албан хаагчдын компьютер, принтер бусад техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллав.

“Кибер аюулгүй байдал ба Цахим орчин дахь гэмт явдал” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж, шүүгчийн сургалтын хөтөлбөрийн хороогоор магадлан итгэмжлүүлсэн байна.

Шүүхийн байранд ашиглаж байгаа цацрагийн үүсгүүрийн ашиглалтын бүртгэл, жилийн эцсийн тооллогын дүн, дотоод хяналтын тайланг гаргаж Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах зорилгоор аюулгүйн үзлэг шалгалт хийн, цацрагийн 2 төхөөрөмжид тус бүрд нь техник ашиглалтын паспорт үүсгэн, рентген төхөөрөмж ажиллуулдаг хамгаалалтын ажилтнуудад заавар, зөвлөгөө өгч, сургалт явуулжээ.

#### 4.2.ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА:

Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн талаарх тоон мэдээллийг нэгтгэн харуулбал:



Шүүхийн цахим хуудсаар мэдээлсэн хуралдааны тоон үзүүлэлт:



## Шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан тогтоол:



Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу шүүх хуралдааны явцыг тухай бүр дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулан архивт хадгалж, хяналтын шатны 1776 шүүх хуралдаанд цахимаар 2287, танхимаар 1406 хэргийн оролцогчийг оруулсан байна.


Мөн “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем ашиглах журам”-ын дагуу баримтлан 1621 шүүх хуралдааны явцын мэдээллийг <http://live.shuukh.mn> болон [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) цахим хуудсаараа дамжуулан хэргийн оролцогч, иргэд, олон нийтийг тухай бүр мэдээллээр ханган ажиллажээ.

### 4.3. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДЛАЛ:

Хяналтын шатны шүүхийн 2022 оны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа, насжилтын судалгаа, Танхим болон шүүгчдээс ирүүлсэн захиалгын дагуу эрүүгийн хэргийн талаарх 14, иргэний хэргийн талаарх 33, захиргааны хэргийн талаарх 15 судалгаа, шүүх хуралдаанаар хянагдсан эрүү, иргэн, захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тогтоол, магадлалыг судалсан тухай тойм зэргийг хийж гүйцэтгэв.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн өгөгдлийн санг баяжуулах, мэдээллийг судалгааны эргэлтэд оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж 2021 оны эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолыг (100%) бүрэн оруулж, 2022 оны эрүүгийн хэргийн 114, иргэний хэргийн 400, захиргааны хэргийн 47 албажсан тогтоолыг өгөгдлийн санд оруулжээ.

Хуулийн төсөл санаачлагчаас санал авахаар ирүүлсэн дараах хуулийн төслүүдэд санал өгөх, уламжлах ажлыг зохион байгуулав.



## ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ДУНДАЖ ХУГАЦАА, НАСЖИЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА


Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.25 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа, насжилтын талаарх судалгаа хийсэн.

**Судалгааны зорилго:** Монгол Улсын дээд шүүх хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн байдлыг хэрэг маргааны төрөл, шийдвэрлэсэн хугацаагаар ангилж, хуульд заасан хугацааг хэтрүүлсэн байдал, шалтгааныг тодорхойлох.

### Зорилт:

- Дурдсан хугацааны хэргийн хөдөлгөөний мэдээлэлд тулгуурлан хянан шийдвэрлэх хэргийг төрөлжүүлэх;
- Нийт хүлээн авч шийдвэрлэсэн хэргийг хянан шийдвэрлэсэн хугацаагаар нь ангилах;
- Хуульд заасан хугацааг хэтрүүлсэн хэргүүдийг төрлөөр нь ялгамжлах;
- Хуульд заасан хугацааг хэтрүүлсэн шалтгааныг тодорхойлох.

Судалгааг эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимаар ялгаж гүйцэтгэв.




Хяналтын шатны шүүхийн 2021, 2022 онд хянан шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийг гэмт хэргийн төрлөөр нь ангилан үзвэл:

№	Гэмт хэргийн төрөл	2021		2022		(+) (-) буурсан хувь	
		хэрэг	хувь	хэрэг	хувь	хэрэг	хувь
1	Хүчиндэх	31	9.6	45	23.9	+14	+45.2
2	Хүнийг алах	33	10.2	22	11.7	-11	-33.3
3	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	26	8.1	22	11.7	-4	-15.4
4	Авлигын эсрэг гэмт хэрэг	15	4.7	16	8.5	+1	+6.6
5	Залилах	36	11.2	14	7.4	-22	-61.1
6	Хулгайлах, мал хулгайлах	32	10.0	10	5.3	-22	-68.7
7	Хүний эрүүл мэндэд хүнд болон хүндэтэр хохирол санаатай учруулах	21	6.5	8	4.3	-13	-61.9
8	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	31	9.6	8	4.3	-23	-74.2
9	Бусад гэмт хэрэг	97	30.1	43	22.9	-54	-55.7
<b>10</b>	<b>Нийт</b>	<b>322</b>	<b>100</b>	<b>188</b>	<b>100</b>	<b>134</b>	<b>-41.6</b>



Иргэний хэргийн танхим  
дунджаар 23.1 хоног




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн 1291 хэргийг хэрэглэсэн хуулиар төрөлжүүлбэл: Иргэний хуулиар 1136, Хөдөлмөрийн тухай хуулиар 43, Гэр бүлийн тухай хуулиар 6, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 5, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар 13, бусад хуулиар 88 хэргийг тус тус хянан шийдвэрлэснийг 2021 онтой харьцуулж үзвэл:

№	Маргааны төрөл	2021		2022		(+) өссөн (-) буурсан хувь	
		хэрэг	хувь	хэрэг	хувь	хэрэг	хувь
1	Иргэний хуулиар	904	57.4	1136	88.0	232	+25.7
2	ИХШХШТХ-иар	17	1.1	13	1.0	-4	-23.5
3	Гэр бүлийн тухай хуулиар	97	6.2	6	0.5	-91	-93.8
4	Хөдөлмөрийн тухай хуулиар	247	15.6	43	3.3	-204	-82.6
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	272	17.3	5	0.4	-267	-98.2
6	Бусад хуулиар	39	2.5	88	6.8	49	+125.6
7	Нийт	1576	100	1291	100	-285	-18

Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2022 онд 535 хэрэг хүлээн авснаас 84 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байна. Тус 84 хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 25.33 хоног.

Захиргааны хэргийн танхим  
дунджаар 25.33 хоног




Хяналтын шатны шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2021 болон 2022 онд хянан шийдвэрлэсэн маргаануудыг төрлөөр нь ангилж харьцуулбал дараах байдалтай байна.

№	Маргааны төрөл	2021		2022		(+) өссөн (-) буурсан хувь	
		хэрэг	хувь	хэрэг	хувь	хэрэг	хувь
1	Газар	30	20.7	9	10.7	-21	-70
2	Төрийн албан хаагч хөдөлмөр	19	13.1	8	9.5	-11	-57.9
3	Ашигт малтмал	21	14.5	11	13.1	-10	-47.6
4	Татвар	13	9.0	10	11.9	-3	-23
5	Сонгууль	2	1.4	0	0	-2	-100
6	Төрийн хяналт шалгалт	9	6.2	2	2.4	-7	-77.7
7	Эд/Хөр өмчлөх эрхийн улсын бүртгэл	4	2.8	2	2.4	-2	-50
8	Нийгмийн даатгал	5	3.4	3	3.6	-2	-40
9	Тусгай зөвшөөрөл	3	2.1	4	4.8	+1	+33.3
10	Хуулийн этгээдийн улсын бүртгэл	3	2.1	1	1.2	-2	-66.6
11	Тендер	14	9.7	2	2.4	-12	-85.7
12	Өмч/Орон сууц/ хувьчлах	0	0	1	1.2	+1	
13	Төрийн болон ор/нут-н өмч	1	0.7	0	0	-1	-100
14	Оюуны өмч	3	2.1	1	1.2	-2	-66.6
15	Зөрчил торгууль	3	2.1	3	3.6	0	0
16	Нийтийн эрх ашиг	1	0.7	1	1.2	0	0
17	Хуульчийн мэргэжлийн хариуцлага	1	0.7	11	13.1	+10	
18	Хэрэглэгч эрх ашиг, шударга өрсөлдөөн	2	1.4	5	6.0	+3	+150
19	Санхүү	0	0	2	2.4	+2	
20	Нутгийн өөрөө удирдах ёс	0	0	1	1.2	+1	
21	Гааль	3	2.1	1	1.2	-2	-66.6
22	Барилга	2	1.4	2	2.4	0	0
23	Бусад	6	4.1	4	4.8	-2	-33.3
24	Нийт	145	100	84	100	-61	-42

#### 4.4.ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛ

Хяналтын шатны шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаарх нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн үйл ажиллагааг сурталчлах зорилтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Монгол Улсын дээд шүүхээр хянан шийдвэрлэсэн олон нийтийн анхаарал татсан хэрэг хянан шийдвэрлэх болон бусад үйл ажиллагааны талаар 102 мэдээг сонин, сайт, телевиз, радиод давхардсан тоогоор нийт 1711-ийг нийтэлж, нэвтрүүлж, олон нийтэд хүргэлээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мэдээ, олон нийтэд хүргэсэн тоо тус бүр 0.9 хувиар өссөн байна. 2022 онд шүүн таслах ажлын мэдээ цөөрч, нийт шүүгчийн хуралдаан, хуулийн тайлбар болон бусад мэдээллээр төрөлжсөн байна.



Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22.10, 22.11 дэх хэсэгт заасны дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэж, шүүхийн цахим хуудсанд нийтэлдэг болсон. Тайлант онд шүүхийн шийдвэрийн 24 хураангуй нийтэлснийг давхардсан тоогоор 489 хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэв.

Мөн Монголын Үндэсний олон нийтийн радиотой хамтран шүүхийн шийдвэрийн хураангуйг тус радиогийн “Соёмбо” нэвтрүүлгээр нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, аудио хэлбэрээр бэлтгэсэн хувилбарыг шүүхийн цахим хуудсанд байршуулахаар бэлтгэсэн байна.

Шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрлэсэн хэрэг болон бусад асуудлаар олон нийтэд зөв ойлголт төрүүлэх үүднээс нийтлэл, дэлгэрэнгүй мэдээлэл 19-ийг бэлтгэснийг давхардсан тоогоор 82 сонин, сайтад нийтлүүлэн олон нийтэд хүргэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4-т заасны дагуу Монгол Улсын дээд шүүхээс гаргасан албан ёсны хуулийн 7 тайлбарыг нийт 11 сайтад нийтлүүлсэн байна.

Цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 81 сэдэв, асуудлаар давхардсан тоогоор 400 орчим сэтгүүлчээс ирсэн асуулт, хүсэлт хариулж, Ерөнхий шүүгч, шүүгч нарыг мэдээллээр шуурхай хангах зорилгоор ажлын өдөр бүр өдөр тутам сонин, сайтад гарсан мэдээллийг тоймлон хүргэж ажиллажээ.

Монгол Улсын дээд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, сэтгүүлчдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шүүхийн талаар бодит ойлголтыг төлөвшүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгын хүрээнд 2022 оны 3 дугаар сарын 11, 12-ны өдөр “Шүүхийг сурвалжлах нь” сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгууллаа. Сургалтад эрэн сурвалжлах, хууль эрх зүйн чиглэлээр дагнан ажилладаг 30 сэтгүүлч оролцсон бөгөөд Монгол Улсын дээд шүүхийн сургагч багшийн эрх бүхий 5 шүүгч болон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал хичээл зааж, мэдээлэл солилцсон байна.

Шүүхийн [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) цахим хуудсанд цаг үеийн үйл явдалтай холбоотой 121 мэдээ, мэдээллийг нийтэлж, “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх” сэдвээр Улсын дээд шүүхийн шүүгч Д.Мөнхтуяа 25 сэтгүүлчтэй чөлөөт уулзалт хийсэн.

Тайлант хугацаанд Ерөнхий шүүгчийн мэндчилгээ, уулзалт, сургалт нийт 9 арга хэмжээний 12 удаагийн дүрс бичлэг хийж, цаг үеийн үйл явдал зэрэгтэй холбоотой нийт 17 арга хэмжээний зураг авч, Монгол Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн сургалтын 42 удаагийн нийт 72 цагийн бичлэгийг хийж, хүлээлгэн өгсөн байна.

Шүүхийн шийдвэрийн хураангуйн мониторинг 1, Түгээлт, олон нийтийн хандлагын талаарх судалгааг 2 удаа хийж танилцуулав.

#### 4.5.ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахал болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төлөвлөгдсөн айлчлал, сургалтууд тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Цахимаар болон зохион байгуулагч талын урилгаар зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцсон тухай мэдээллийг нэгтгэн хүргэвэл:

##### ***Цахимаар оролцсон хурал, зөвлөгөөн:***

- Ази, Номхон далайн бүсийн орнуудын Ерөнхий шүүгчдийн 18 дугаар хурал;
- БНХАУ-ын Ардын дээд шүүхээс цахимаар зохион байгуулсан “Дижитал, Хууль эдийн засгийн форум”.

##### ***Зохион байгуулагч талын урилгаар оролцсон хурал, зөвлөгөөн:***

- ХБНГУ-ын Берлин хотноо тус улсын Холбооны эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн яамнаас зохион байгуулсан “Засаглал ба Фонд” төслийн түншлэгч орнуудын чуулга уулзалт;
- Нидерландын Хаант Улсын Гаага хотноо зохион байгуулсан Гаагийн олон улсын эрх зүйн академийн “Нийтийн болон хувийн олон улсын эрх зүй” сэдэвт зуны сургалт;
- Сингапур улсын Дээд шүүхээс зохион байгуулсан “Технологи ба ирээдүйн шүүх” сэдэвт сургалт;
- Канад Улсын Онтарио мужийн Торонто хотод зохион байгуулагдсан Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага болон Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд гэр бүлийн шүүх, гэр бүлийн хүчирхийллийн хэргийн дагнасан шүүхтэй танилцах, Канад улсын сайн туршлагыг судлах нь” сэдэвт туршлага судлах айлчлал;
- Канадын Холбооны Улсаас зохион байгуулсан “Олон улсын шүүгчийн боловсролын тухай” хурал;
- БНЭУ-ын Лакноу хотноо зохион байгуулагдсан Дэлхийн Ерөнхий шүүгч нарын дээд хэмжээний уулзалт.

**Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хийсэн уулзалтууд:**

Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Себастиан Сүрүн

Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Аксель Никэйз

АНУ-ын Мужийн шүүхийн үндэсний төвийн дэд ерөнхийлөгч Майкл Бингер, Гадаад харилцааны дэд ерөнхийлөгч Жеффри Апперсон

Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн суурин төлөөлөгч Стивен Кент, төслийн зөвлөх Сара Вудкок

Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын дэд тэргүүн Марко Ферри, мэргэжилтэн Евгения Фараза

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын Монгол Улсыг хариуцсан ажилтан Себастьян Гиёо

#### ШҮҮХИЙН ДААЛГАВАР:

Монгол Улсын дээд шүүхээс Бүгд Найрамдах Солонгос Улсад-3, Америкийн Нэгдсэн Улсад-2, Тайван Улсад-1, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад-1, Гренада Улсад-1, Беларусь Улсад-1, нийт 9 шүүхийн даалгавар илгээж, хилийн чанадаас нийт 12 буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас-2, Бүгд Найрамдах Солонгос Улсаас-8, Бүгд Найрамдах Чех Улсаас-1, Австри Улсаас-1 шүүхийн даалгавар тус тус ирснийг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авч 5 даалгаврын хариуг буцаан илгээсэн байна.

#### 4.6. САНХҮҮ, НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар баталсан төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж ажиллав.



#### 4.7.ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТ

Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.25-д заасан хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилтын талаар хяналт-шинжилгээ хийх чиг үүргийн хүрээнд Тамгын газраас 2023 оны 1 дүгээр улиралд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын удирдамж батлан хэрэгжүүлсэн байна. Үүнд.

1. Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулахад тавигдах техникийн шаардлагын хэрэгжилт;
2. Шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах, хадгалах ажлын хэрэгжилт;
3. Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системийн ашиглалт;
4. Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал болон шүүхэд албан хөтлөх журмын хэрэгжилтийн тухай асуудлуудыг үзэж шалган тус бүр илтгэх хуудас бичиж, зөвлөмж өгч ажиллажээ.



-----oOo-----